

Тогтсон загварын дагуу баримт
НОТОЛГООНД ҮНДЭСЛЭН, ИЛТГЭХ
хуудас бичих

Хичээлийн зорилго

- ❑ Загварт найруулгаар эх зохиох аргад суралцах
- ❑ Нотолгоо, баримтаар дэлгэрүүлэн бичих



Илтгэх хуудасны эхлэл хэсгийг ажиглаарай. Өгөгдсөн баримтуудаас тохирох баримтыг ялган бичье

Агуулгатай холбоотой ялгасан баримтууд

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН
ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

"Монгол бахархал-3000" морин хуурчдын
тоглолтыг зохион байгуулсан тухай

2018 оны 09 дүгээр сарын 20 Улиастай хот

"Морин хуураа дээдлэн,
дэлгэрүүлэх тухай" Монгол Улсын
ерөнхийлөгчийн 2002 оны 02
дугаар сарын 11-ний өдрийн №17
тоот зарлиг, "Хүүхдийн эрхийн
тухай хууль"-ийн 9-р зүйл 9.1.6
–г үндэслэн үндэсний урлаг
соёлоо хамгаалах, хөгжүүлэх,
өвлүүлэх зорилгоор "Монгол
бахархал-3000" тоглолтыг зохион
байгууллаа.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН

- ★ 7-70 хүртэл насны 3030 хуурч
- ★ 3 дэд овог, 8 зүйлд хуваагдана
- ★ Орхон, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Ховд, Хөвсгөл, Нийслэлийн 7 дүүрэг
- ★ Товчлуурыг дармагц жижигхэн алх тусгай механик үйлдлээр чавхдасыг цохин дуугардаг хөгжмийн зэмсэг юм.
- ★ Чингис хаан 1206 онд Их Монгол Улсыг байгуулан монгол угсаатныг дахин сэргээн мандуулж, эдүгээ хүртэл оршин байх үндсийг бататгасан билээ.
- ★ Завхан аймгийн 29 сургуулийн 1000 гаруй сурагч
- ★ хэлбэр, хийц энгийн атлаа өвөрмөц тансаг аялгуугаараа хөгжим сонирхогчдын анхаарлыг татаж дэлхийн 160 гаруй оронд тархсан
- ★ үндэсний бахархал, төрийн хан хуураа өвлүүлэн дэлгэрүүлэх гэгээн үйл хэргийн эхлэл
- ★ Дэлхийн дээд амжилтыг тогтоох уг арга хэмжээний нээлтэд Монгол Улсын Ерөнхий сайд оролцлоо.

- 7-70 хүртэл насны 3030 хуурч
- Орхон , Дорноговь , Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Ховд, Хөвсгөл , Нийслэлийн 7 дүүрэг
- Завхан аймгийн 29 сургуулийн 1000 гаруй сурагч
- хэлбэр хийц, энгийн атлаа өвөрмөц тансаг аялгуугаараа хөгжим сонирхогчдын анхаарлыг татаж дэлхийн 160 оронд тархсан.
- Үндэсний бахархал, төрийн хан хуураа өвлүүлэн дэлгэрүүлэх гэгээн үйл хэргийн эхлэл
- Дэлхийн дээд амжилтыг тогтоох уг арга хэмжээний нээлтэд Монгол Улсын Ерөнхий сайд оролцлоо.

Ялгасан баримтуудаа холбон найруулж бичээрэй

Оноосон нэрээр зэрэгцүүлэн
тоочиж бичсэн байна.

Тус арга хэмжээнд Завхан аймгийн 29 сургуулийн 1000 гаруй сурагч , Орхон ,Дорноговь , Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Ховд, Хөвсгөл , Нийслэлийн 7 дүүргийн 7-70 хүртэл насны 3030 хуурч оролцлоо.

Хуур хөгжим нь хэлбэр хийц, энгийн атлаа өвөрмөц тансаг аялгуугаараа хөгжим сонирхогчдын анхаарлыг татаж дэлхийн 160 оронд тархсан.

Дэлхийн дээд амжилтыг тогтоох уг арга хэмжээний нээлтэд Монгол Улсын Ерөнхий сайд оролцсон ба энэ арга хэмжээ нь үндэсний бахархал, төрийн хан хуураа өвлүүлэн дэлгэрүүлэх гэгээн үйл хэргийн эхлэл болсон юм.

“Ба “
зэрэгцүүлэн
холбох үгээр
холбосон.



Албан хэрэг хөтлөлтийн тухай

Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар

2.2.4. Баримт бичгийн хэвлэмэл хуудсыг цагаан буюу цайвар өнгийн цаасан дээр бэлтгэнэ. Баримт бичгийг хэвлэмэл хуудсанд байрлуулахдаа бичвэрийн талбай нь цаасны зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм, дээд захаас 20 мм, доод захаас 20 мм-ээс доошгүй байхаар тохируулна.

2.3.6. Баримт бичгийн огноо араб тоогоор он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ. Өдөр ба сарын тоог цэгээр зааглан, хоёр хос араб тоогоор, харин оныг дөрвөн араб тоогоор тэмдэглэнэ.
Жишээ нь: 2007.03.06



Архив, албан хэрэг хөтлөлт



Баримт бичгийн бүрдлийг хуудсанд байрлуулахдаа захын ХЭМЖЭЭГ

/Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар. АЕГ-ын даргын 2009 оны 68 дугаар тушаал/

Цаасны хэмжээ:

Дээд захаас 20 мм-ээс доошгүй
Доод захаас 20 мм-ээс доошгүй
Зүүн захаас 30 мм
Баруун захаас 15 мм-ээс доошгүй

A4 /210x297мм/
A4 /297x210 мм/
A5 /148x210мм/



Баримтыг ашиглан гол ба төгсгөл хэсгийг гүйцээн бичье

2см

ГЭР БҮЛ ХҮҮХЭЛ,ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Байгууллагын нэр

ИЛТГЭХ ХУУДАС

Баримт бичгийн нэр

“Монгол бахархал- 3000” морин хуурчдын тоглолтыг зохион байгуулсан тухай

Тэргүү буюу гарчиг

огноо

2018 оны 09 дүгээр сарын 20

Улиастай хот

Үйлдсэн газар

3 см

Эхлэл

“ Морин хуураа дээдлэн,дэлгэрүүлэх тухай” Монгол Усын ерөнхийлөгчийн 2002 оны 02 дугаар сарын 11 –ны өдрийн № 17 тоот зарлиг, “ Хүүхдийн эрхийн тухай хууль”-ийн 9-р зүйл 9.1.6-г үндэслэн үндэсний урлаг соёлоо хамгаалах , хөгжүүлэх, өвлүүлэх зорилгоор “Монгол бахархал-3000” тоглолтыг зохион байгууллаа.

1,5 см

Гол

Уг арга хэмжээнд Завхан аймгийн 29 сургуулийн 1000 гаруй сурагч , Орхон ,Дорноговь , Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Ховд, Хөвсгөл , Нийслэлийн 7 дүүргийн 7-70 хүртэл насны 3030 хуурч оролцлоо.

Үндэслэл,
зорилго

Хуур хөгжим нь хэлбэр хийц, энгийн атлаа өвөрмөц тансаг аялгуугаараа хөгжим сонирхогчдын анхаарлыг татаж дэлхийн 160 оронд тархсан.

Төгсгөл

Дэлхийн дээд амжилтыг тогтоох уг арга хэмжээний нээлтэд Монгол Улсын Ерөнхий сайд ор олцсон ба_энэ арга хэмжээ нь үндэсний бахархал, төрийн хан хуураа өвлүүлэн дэлгэрүүлэх гэгээн үйл хэргийн эхлэл болсон юм.

Үр дүн

ИЛТГЭХ ХУУДСЫГ БИЧСЭН \С.Цэцэгмаа\

Албан бичгийг бичсэн хүний нэр, гарын үсэг

2 см

Баримт нотолгоог ашиглан илтгэх хуудас бичье

- ✦ Ойн тухай хууль
- ✦ Монгол Улсын ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлиг
- ✦ Цэцэрлэгт хүрээлэнд 350 суулгац тарилаа.
- ✦ Чацаргана, нэрс, үхрийн нүд
- ✦ Цаашид хүрээлэнгийн ажилтнууд хариуцаж ургуулах юм байна.
- ✦ 500 бэлдэц үрийг
- ✦ мод, бут, сөөг, цэцэг тарих, цаашид арчлан хамгаалах
- ✦ Монгол Улсын ерөнхий сайд
- ✦ Төрийн өмчийн компани болон ТББ-ууд
- ✦ Ойн санг сайжруулах, ногоон орчин бүрдүүлэх
- ✦ Хорооны иргэдийн оролцоо



ҮНДЭСНИЙ СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН

ИЛТГЭХ ХУУДАС

“Мод тарих аян”-ыг зохион байгуулсан тухай

2019 оны 5дугаар сарын 3

Улаанбаатар хот

“Монгол улсын ойн тухайн хууль”, Монгол улсын ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийг үндэслэн Монгол улсын ерөнхий сайдын санаачилгаар ойн санг сайжруулах, ногоон орчинг бүрдүүлэхээр “Мод тарих” аяныг зохион байгууллаа.

Тус үйл ажиллагаанд хорооны иргэд, төрийн өмчийн компани болон ТББ-ууд хамтран оролцлоо. Тэд цэцэрлэгт хүрээлэнд чацаргана, нэрс, үхрийн нүд зэрэг 350 суулгац, мод, бут, сөөг, цэцэг зэрэг 500 бэлдэц үрийг суулгасан ба цаашид | хүрээлэнгийн ажилчид хариуцаж, арчлан хамгаалж, ургуулахаар болов.

Энэ үйл ажиллагааг зохион байгуулснаар цэцэрлэгт хүрээлэнгийн өнгө үзэмж, иргэдийн эрүүл амьдрах, чөлөөт цагаа өнгөрөөх цэвэр агаартай, ногоон орчин сайжирсан юм.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН ОЙН МЭРГЭЖИЛТЭН \Г. Даш \

Гэрийн даалгавар: Зургийг сайн ажигла. Ямар үйл явдал болсон талаар дараах загварын дагуу илтгэл хуудас бичээрэй. Бичихдээ ЗНӨ ашиглаарай.



.....СУРГУУЛЬ

ИЛТГЭХ ХУУДАС

..... зохион байгуулсан тухай

..... оны ... дугаар сарын ...

Улаанбаатар хот

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН \..... \

Анхаарал таьсанд баярлалаа